

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 6-р сарын 25 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.16-д заасныг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

1. Компанийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах болон брокер, дилерийн эрх сэргээлгэхэд компанид нэн шаардлагатай байгаа 515.000.000 /таван зуун арван таван сая/ төгрөгийн их хэмжээний хэлцэлийг компанийн хувьцаа эзэмшигч Г.Оюунболдтой хийхийг зөвшөөрсүгэй.
2. Уг хэлцэлийн буюу хувьцаа эзэмшигчийн мөнгөн хөрөнгөөр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасугай.
3. Компанийн санхүүгийн байдлаас шалтгаалж хувьцаа эзэмшигч Г.Оюунболдтой хийсэн их хэмжээний хэлцэлийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх боломжгүй тул өрийг хувьцаагаар солих эсхүл зарласан хувьцаанаас гаргах, нэмж гаргах зэрэг аргуудаар шийдсүгэй.
4. Компанийн үйл ажиллагаа явуулах эрх сэргээх ажлыг яаралтай хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Г.ОЮУНБОЛД



“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 6-р сарын 25 өдөр


Дугаар 02

Улаанбаатар хот

Сонирхолын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.17-д заасныг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

1. Компанийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах болон брокер, дилерийн эрх сэргээлгэхэд компанид нэн шаардлагатай байгаа 515.000.000 /таван зуун арван таван сая/ төгрөгийн сонирхолын зөрчилтэй хэлцэлийг компанийн хувьцаа эзэмшигч Г.Оюунболдтой хийхийг зөвшөөрсүгэй.
2. Уг хэлцэлийн буюу хувьцаа эзэмшигчийн мөнгөн хөрөнгөөр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасугай.
3. Компанийн үйл ажиллагаа явуулах эрх сэргээх ажлыг яаралтай хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Г.ОЮУНБОЛД

